

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭЖИЙЛЭГЧИЙН АГЕНТДЭГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙНГ БРӨНХҮЙН ГАЗАР
УЛСЫН БҮРТГЭГЧ 1.1.100

Хуулийн этгээлийн улсын бүртгэлийн
дугаар 9072018008
2023 он 01 сарын 19 өдөр
Бүртгэсэн: Улсын (ахлах) бүртгэлийн
гарын үсэг

**МОНГОЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМГААЛАЛТЫН НЭГДСЭН
ХОЛБООНЫ ДҮРЭМ**

Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХОЛБООНЫ АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ.....	2
ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ҮНДСЭН ЧИГЛЭЛ	3
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	3
ТАВДУГААР БҮЛЭГ: ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ	6
ЗУРГАА ДУГААР БҮЛЭГ: ХОЛБООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	8
Нэгдүгээр дэд бүлэг. Холбооны Их хурал	8
Хоёрдугаар дэд бүлэг. Холбооны Удирдах зөвлөл.....	11
Гуравдугаар дэд бүлэг. Холбооны Ерөнхийлөгч.....	16
Дөрөвдүгээр дэд бүлэг. Холбооны Гүйцэтгэх захирал.....	17
ДОЛООДУГААР БҮЛЭГ: ХОЛБООНЫ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО.....	19
НАЙМДУГААР БҮЛЭГ: ХОЛБООНЫ САНХҮҮ	20
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: БУСАД.....	21



МОНГОЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМГААЛАЛТЫН НЭГДСЭН ХОЛБООНЫ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл: Ерөнхий зүйл

- 1.1 Монголын Аюулгүй Байдал, Хамгаалалтын Нэгдсэн Холбоо нь (цаашид "Холбоо" гэх) мэргэжлийн этгээдүүдийг нэгтгэсэн, гишүүдэд үйлчилдэг, өөрөө удирдах ёсны, Аюулгүй байдал, хамгаалалтын салбарын мэргэжлийн ашгийн бус байгууллага байна.
- 1.2 Холбоо нь үйл ажиллагаандаа Монгол улсын үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Хувийн хамгаалалтын тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Монгол улсын Олон улсын гэрээ, хэлэлцээр, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, Аюулгүй байдал ба хамгаалалтын ажил үйлчилгээний стандарт MNS 6908:2021, Хамгаалалтын дохиоллын тоног төхөөрөмжийн техникийн үндсэн үзүүлэлт. Угсралт суурилуулалт, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5843:2008-ийг мөрдлөг болгон ажиллана.
- 1.3 Холбоо нь өөрийн үйл ажиллагаагаар эрх эдэлж, үүрэг хүлээх чадвартай, банкинд харилцах данстай, өөрийн нэр, бэлэг тэмдэг бүхий тамга, тэмдэг, далбаа, албан бичгийн хэвлэмэл хуудас, цахим хуудас, хэвлэлтэй байна.
- 1.4 Холбооны оноосон нэр: Монгол хэлээр "Монголын Аюулгүй Байдал, Хамгаалалтын Нэгдсэн Холбоо" буюу товчилсноор "МАБХНХ", Англи хэлээр Mongolian Security Industry Association
- 1.5 Холбооны бүртгэгдсэн албан байршил, шуудангийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хотод байна. Цахим шуудан: info@MSIA.mn: вэб хаяг: www.msia.mn

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХОЛБООНЫ АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ

- 2.1 Алсын хараа: Аюулгүй байдал, хамгаалалтын салбарын хөтөч байж, шинэ шийдлийг ямагт эрэлхийлэн, ажил үйлчилгээг дэлхийн жишигт нийцүүлнэ.
- 2.2 Эрхэм зорилго: Аюулгүй байдал, хамгаалалтын салбарын байгууллага, ажилтны эрх зүйн байдал, нийгмийн хамгааллыг сайжруулах, сургаж хөгжүүлэх, харилцаа хандлагыг төлөвшүүлэх замаар хэрэглэгч үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, иргэд олон нийтийн үнэлэмжийг дээшлүүлнэ.



2.3 Үнэт зүйлс: Ёс Зүй, Манлайлал, Хүндлэл, Нэгдмэл байдал, Нийгмийн хариуцлага

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ҮНДСЭН ЧИГЛЭЛ

3.1 Холбоо нь энэхүү дүрэмд заасан зорилго, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг эрхэмлэх, хуулийг дээдлэх, аливаа нам, улс төр, шашны үйл ажиллагаанаас ангид, үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан хэлбэрээр ил тод, нээлттэй явуулах, гишүүдийн оролцоог хангах, хамтын удирдлага хэрэгжүүлэх зарчмыг баримтална.

3.2 Холбоо нь гишүүдийн хувийн мэдээлэл, Холбооны оюуны өмчөөр баталгаажсан хөтөлбөр, ном, сурах бичиг, судалгааны материал зэрэг биет болон биет бус мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.3 Холбоо нь дараах үндсэн чиглэл баримтлана.

3.3.1 Байнга суралцагч байгууллага байж, шинэ санаа шийдлийг эрэлхийлж, бусдад түгээнэ.

3.3.2 Байгууллага ажилтны эрх зүйн байдал, нийгмийн хамгааллыг сайжруулахыг бүхий л чиглэлээр эрмэлзэнэ.

3.3.3 Гадаад орны ижил төстэй байгууллагатай хамтран ажиллаж мэдлэг, туршлага хуримтлуулна.

3.3.4 Технологийн дэвшилд суурилсан шинэ ажил үйлчилгээг Монгол улсад нэвтрүүлж, нутагшуулна.

3.3.5 Аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээний үнэлэмжийг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Аюулгүй байдал, Хамгаалалтын салбарын үйл ажиллагаа зохицуулалт:

4.1.1 Салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах.

4.1.2 Салбарын хөгжлийн талаарх олон улсын чиг хандлага, зах зээлийн өөрчлөлтөд бэлтгэх болон дотоодын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, хуваалцах олон улсын ижил төстэй мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах дэмжлэг үзүүлэх.

4.1.3 Салбарын үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох ажлыг санаачлах, сонирхогч талуудын оролцоог хангуулах.



4.1.4 Салбарын үйл ажиллагааг чанаржуулах, цар хүрээг өргөжүүлэх, тухайн салбарт ажиллаж байгаа мэргэжлийн этгээдүүдийг чадавхжуулах.

4.1.5 Салбарын үйл ажиллагаанд баримтлах зарчим, ёс зүйн дүрмийг батлах, сахиулах, холбогдох зөрчлийн талаарх гомдлыг шийдвэрлэх, гишүүдийг мэргэжлийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.

4.1.6 Салбарын үйл ажиллагааны чанар, зохион байгуулалтыг сайжруулах замаар олон нийтийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах.

4.2 Судалгаа, хөтөлбөр хөгжүүлэлтийн чиглэлээр

4.2.1 Салбарын чиглэлээр мэргэшүүлэх, чадвахжуулах хөтөлбөрийн бодлогыг үндэсний хэмжээнд тодорхойлж нэвтрүүлэхэд мэргэжлийн байгууллагууд, судлаачидтай хамтран ажиллах;

4.2.2 Холбооны бүх төрлийн сургалтын болон мэргэжлийн зэрэг, хуулиар зөвшөөрөгдсөн эрх олгох хөтөлбөрүүдийг боловсруулах, төрөлжүүлэх, тасралтгүй сайжруулах;

4.2.3 Мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтын хөтөлбөр, мэргэжлийн ном, сурах бичиг, сургалт, шалгалтын агуулгын уялдааг хангах;

4.2.4 Аюулгүй байдал, хамгаалалтын салбарын үйл ажиллагааны чиглэлээр холбогдох судалгаа хийж, арга зүй боловсруулах;

4.2.5 Аюулгүй байдал, хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

4.2.6 Салбарын холбогдолтой Олон улсын стандарт, мэдээ, мэдээллийг Монгол хэлнээ хөрвүүлж гишүүд, олон нийтэд хүргэх.

4.3 Салбар, гишүүдийн хөгжил

4.3.1 Гишүүдийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах, тэдний нийтлэг эрх ашиг зөрчигдсөн асуудлаар холбогдох байгууллагуудад санал, хүсэлт тавьж, шаардлагатай арга хэмжээ авах;

4.3.2 Гишүүдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх;

4.3.3 Гишүүдэд менежментийн зөвлөгөө, зөвлөмж олгож үйлчилгээний стандартыг нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлэх;



4.3.4 Гишүүдийн нийгмийн байр суурь, нөлөөллийг нэмэгдүүлэх чиглэлээр бусад байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах;

4.3.5 Холбогдох хууль тогтоомж, Холбооны дүрэм, бодлогын баримт бичгийн боловсруулалтад гишүүдийн оролцоог хангах;

4.3.6 Холбоо нь гишүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжлийн нэр хүндийг өргөх, нийт гишүүдийн идэвх санаачилгыг дэмжсэн төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулах;

4.3.7 Гишүүдийн нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлэх, Нэгдсэн мэдээллийн сангийн бүтэц, мэдээллийн ангилал, ашиглалтыг тусгайлсан журмаар зохицуулах, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

4.3.8 Салбарт ажиллагсдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, нийгмийн баталгааг дээшлүүлэх,

4.3.9 Эрх нь зөрчигдсөн ажилтны зөрчигдсөн эрхийг сэргээх тухай шаардлагыг холбогдох удирдлагад хүргүүлэх, хангуулах шаардлагыг тавих,

4.3.10 Салбарт ажиллагсдын цалин хөлсний доод жишгийг тогтоох, гэрээний үнийн доод босгыг тогтоож мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих.

4.4 Хамтын ажиллагааны чиглэлээр

4.4.1 Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх, олон талт хамтын үйл ажиллагааг явуулах;

4.4.2 Олон улсын мэргэжлийн холбоодод гишүүнээр элсэх, гишүүний үүргийн биелэлтийг хангах;

4.4.3 Холбоо нь холбогдох үйл ажиллагааны чиглэлээр төрийн болон бусад байгууллагатай хамтран ажиллах;

4.4.4 Гишүүдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн болон бусад байгууллагатай зөвшилцөх, мэргэжлийн санал, зөвлөмж, дүгнэлт хүргүүлэх;

4.4.5 Холбоо нь нийгэмд хүртээмжтэй, олон нийтийг хамарсан арга хэмжээ, төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх, мэдээлэх, сурталчлах;

4.5 Сургалт, шалгалт

4.5.1 Холбогдох төрийн байгууллагаас тухайлан эрх олгосон тохиолдолд Аюулгүй байдал, хамгаалалтын салбарт ажиллаж байгаа байгууллага, хувь хүнд эрх олгох, эрх



сунгах, стандартын шаардлага хангуулах, мэргэжлийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулах;

4.5.2 Холбогдох төрийн байгууллагаас тухайлан эрх олгосон тохиолдолд шалгалтыг эрх бүхий төрийн байгууллагын албан тушаалтан, батлагдсан комиссын хамт зохион байгуулах;

4.5.3 Холбооноос олгож буй мэргэжлийн зэрэг болон мэргэшүүлэх шалгалтын санг холбогдох хууль тогтоомж, мэргэжлийн стандартуудад нийцүүлэн тасралтгүй шинэчлэх;

4.5.4 Холбооноос олгож буй эрх олгох, сунгах, чадавхи тодорхойлох, мэргэжил олгох мэргэжлийн зэрэг олгох зэрэг шалгалт авахад хууль журмын дагуу шалгалтын комисс бүрдүүлэх;

4.6 Холбоо нь энэхүү дүрэмд заасан зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд шаардлагатай бөгөөд хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг явуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

5.1 дугаар зүйл. Холбооны гишүүн

5.1.1 Холбооны гишүүдийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн Аюулгүй байдал, Хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, хувь хүн гишүүн байна.

5.1.2 Гишүүнд тавигдах шаардлагыг холбогдох хууль болон Холбооны удирдах зөвлөлөөс баталсан журмаар зохицуулна.

5.1.3 Холбооны гишүүний эрх, үүрэг нь гишүүдийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэнээр үүснэ.

5.2 дугаар зүйл. Гишүүний эрх, үүрэг

5.2.1 Холбооны гишүүн нь дараах нийтлэг эрхтэй байна.

5.2.1.1 Холбооны үйл ажиллагаанд оролцох;

5.2.1.2 Холбоонд санал, хүсэлт, гомдол гаргах, шийдүүлэх;

5.2.1.3 Холбоонд хэлэлцэгдэж буй асуудлаар мэдээлэл авах, санал өгөх, санал шүүмжлэл гаргах;

5.2.1.4 Хууль тогтоомж, дүрэм журамд заасан бусад эрх.



5.2.2 Холбооны гишүүн нь дараах нийтлэг үүрэгтэй байна.

5.2.2.1 Холбооны алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг эрхэмлэж ажиллах;

5.2.2.2 Холбооны дүрэм, журмыг даган мөрдөх;

5.2.2.3 Холбооны ёс зүйн дүрмийг чанд сахиж, үнэнч шударга ажиллан, салбарын нэр хүндийг дээдлэх;

5.2.2.4 Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үүрэг.

5.3 дугаар зүйл. Гишүүний эрх, үүргийг түдгэлзүүлэх, сэргээх, дуусгавар болох

5.3.1 Дараах тохиолдолд гишүүний эрх, үүргийг түдгэлзүүлнэ.

5.3.1.1 Гишүүн өөрөө хүсэлт гаргасан;

5.3.1.2 Холбооны олгосон зөвшөөрлийг түдгэлзүүлэх хариуцлага хүлээлгэсэн;

5.3.1.3 Энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомж заасан бусад үндэслэл

5.3.2 Гишүүний эрхийг түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд гишүүн нь гишүүний эрхээ сэргээлгэх хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

5.3.3 Дараах тохиолдолд гишүүний эрх, үүрэг дуусгавар болно.

5.3.3.1 Гишүүн өөрөө хүсэлт гаргасан;

5.3.3.2 Гишүүний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болсон, татан буугдсан, дампуурсан;

5.3.3.3 Гишүүн нас барсан тохиолдол;

5.4 дугаар зүйл. Гишүүнчлэлийн татвар

5.4.1 Холбооны гишүүн нь гишүүнчлэлийн татвар төлнө.

5.4.2 Холбооны гишүүний жилийн татварын хэмжээг Удирдах зөвлөл тогтооно.

5.4.3 Холбооны гишүүдэд татварын чөлөөлөлт, хөнгөлөлт үзүүлж болох бөгөөд тэдгээр харилцааг Удирдах зөвлөлөөс баталсан журмаар зохицуулна.

5.5 дугаар зүйл. Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, гишүүний ёс зүй

5.5.1 Холбооны гишүүд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга байх, аливаа асуудалд бодитой хандах, хараат бус байх, ур чадвартай байх, хариуцлагатай хандах, нууцыг хадгалах, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх, мэргэжлийн



болон салбарын нэр хүндээ эрхэмлэх зарчмуудыг баримтлан, гишүүний ёс зүйн дүрмийг чанд мөрдөнө.

5.5.2 Гишүүний үйл ажиллагаанд дараах зүйлсийг хориглоно.

5.5.2.1 Өөрт эрх олгогдоогүй асуудлаар Холбоог төлөөлөх, түүний нэрийн өмнөөс мэдэгдэл хийх, үйл ажиллагаа явуулах;

5.5.2.2 Холбоонд тодорхой албан тушаал эрхэлж байхдаа болон гишүүний хувьд олж мэдсэн дотоод мэдээлэл эсхүл байгууллага болон хувь хүний нууцыг задруулах;

5.5.2.3 Гишүүн нь ижил төстэй нэртэй байгууллага байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох.

5.5.3 Энэхүү дүрэм болон гишүүдийн үйл ажиллагаанд баримтлах Ёс зүйн дүрэм зөрчсөн эсэх асуудлаар Удирдах зөвлөл болон эрх бүхий хороо шалгаж дүгнэлт гаргана.

ЗУРГАА ДУГААР БҮЛЭГ. ХОЛБООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нэгдүгээр дэд бүлэг. Холбооны Их хурал

6 дугаар зүйл. Холбооны Их хурал, түүний бүрэн эрх

6.1 Холбооны эрх барих дээд байгууллага нь холбооны Их хурал /цаашид "Их хурал" гэх/ байна.

6.2 Их хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.2.1 Холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

6.2.2 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан сонсох, хэлэлцэх;

6.2.3 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, батламжлах, чөлөөлөх,

6.2.4 Холбооны үйл ажиллагааг зогсоох, татан буулгах;

6.2.5 Хууль, энэ дүрэмд заасан бусад.

7 дүгээр зүйл. Ээлжит ба ээлжит бус Их хурал

7.1 Холбооны ээлжит Их хурал хоёр жилд нэг удаа хуралдана. Их хурлыг Удирдах зөвлөл зарлан хуралдуулна.



7.2 Удирдах зөвлөл холбооны Их хурлын тов тогтоохдоо, Их хурал зохион байгуулах Ажлын хэсэг байгуулж, удирдамжийг батална.

7.3 Их хурлын төлөөлөгчдөөс сонгогдсон таван хvний бүрэлдэхүүнтэй тэргүүлэгчид хурлыг удирдана. Хурлын тэргүүлэгчид нь даргаа сонгож, хурлын дэгийг танилцуулж батлуулна.

7.4 Холбооны ээлжит бус Их хурлыг дараах тохиолдолд Удирдах зөвлөл зарлан хуралдуулна.

7.4.1 Холбооны нийт гишүүдийн гуравны нэг нь ээлжит бус Их хурал хуралдуулах хүсэлт гаргасан;

7.4.2 Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн санал, шаардлага гаргасан.

7.5 Ээлжит болон ээлжит бус Их хурлын товыг хурал хуралдах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө Удирдах зөвлөлөөс тогтооно.

7.6 Их хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Удирдах зөвлөл хэлэлцэн баталж, энэ дүрэмд заасан хугацаанд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэнэ. Их хурлыг яаралтай хуралдуулах тохиолдолд нийтэд мэдээлэх хугацаа 14 хоногоос доошгүй хоногийн өмнө байна.

7.7 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас Их хурлыг онцгой нөхцөл байдал арилах хүртэлх хугацаагаар хойшлуулах эсхүл Их хурлын үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах эсэх асуудлыг Удирдах зөвлөлөөс шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл. Их хурлын төлөөлөгч, төлөөлөгч сонгох

8.1 Их хуралд гишүүн байгууллага бүрээс оролцох төлөөлөгчдийн тоог Удирдах зөвлөл тогтооно.

8.2 Их хурлын төлөөлөгч сонгох журмыг дараах нийтлэг зарчимд нийцүүлэн Удирдах зөвлөл батална.

8.2.1 Холбооны гишүүн бүр сонгуульд нэр дэвших, сонгох, сонгогдох эрхтэй байх;

8.2.2 Гишүүн нь Их хурлын төлөөлөгчид зөвхөн өөрийнхөө нэрийг дэвшүүлэх;

8.2.3 Холбооны гишүүдийн ажиллаж буй салбарын төлөөллийг тэнцвэртэй хангах;



8.2.4 Сонгуулийг хууль дээдлэх, ардчилсан ёсны, тэгш эрхтэй, шударга ба ил тод байх зарчмуудыг баримтлан явуулах.

8.3 Их хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь дүрэмд заасан шаардлагыг хангасан этгээд байхаас гадна, ажиллаж буй салбарыг төлөөлж чадахуйц байна.

9 дугаар зүйл. Их хурлын хэлэлцэх асуудлаар санал хураах

9.1 Удирдах байгууллагыг сонгох санал хураалтыг илээр явуулна. Зөвхөн их хурлын төлөөлөгч саналын эрхтэй байна.

9.2 Удирдах байгууллагыг сонгох санал хураалтыг нууцаар явуулах асуудлыг Их хурлын төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар шийднэ.

9.3 Санал өгөх эрхийг бусдад шилжүүлэх, бусдын өмнөөс санал өгөхийг хориглоно.

9.4 Их хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдаж буй үед санал хураалт мөн цахим хэлбэрээр явагдана.

10 дүгээр зүйл. Их хурал болон Их хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

10.1 Их хуралд нийт гишүүдийн олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

10.2 Их хурлаас гарах шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Тогтоолын хүчин төгөлдөр байдал нь тооллогын комиссоос гаргасан санал хураалтын дүнг үндэслэнэ.

10.3 Их хуралд оролцсон төлөөлөгчдийн ердийн олонхын саналаар тогтоол хүчин төгөлдөр болно.

10.4 Их хурлын тогтоолд хурлын дарга, тэргүүлэгчид гарын үсэг зурж, хөлбооны тамгыг дарж баталгаажуулна.

10.5 Их хурлын шийдвэрт өөрөөр заагаагүй бол шийдвэр нь гарсан даруйдаа хүчин төгөлдөр болно.

10.6 Их хурал дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хуралдаан даргалагч гарын үсэг зурна. Хурлын тэмдэглэл болон холбогдох мэдээллийг архивын журмын дагуу хадгална.

11 дугаар зүйл. Тооллогын комисс

11.1 Их хурлаас тухайн хурлын Тооллогын комиссыг батална.

11.2 Тооллогын комисс дараах эрх, үүрэгтэй:



- 11.2.1 Их хурлын санал хураалтад оролцогчдын ирцийг тодорхойлж, хурал даргалагчид мэдээлэх;
- 11.2.2 Санал өгөх журмыг тайлбарлах;
- 11.2.3 Санал өгөх журмын хэрэгжилт болон хуралд оролцогчдын санал өгөх эрхийг хангах;
- 11.2.4 Саналыг тоолж баримтжуулан, дүнг нэгтгэж, энэ тухай тогтоол гаргаж, санал хураалтын тооллогын комиссын дарга, гишүүдийн гарын үсгээр баталгаажуулан Их хуралд танилцуулах;
- 11.2.5 Тооллогын комиссын шийдвэр, саналын хуудас, холбогдох бусад материалыг Холбооны архивд хадгалуулахаар хүлээлгэж өгөх;
- 11.2.6 Нууцаар санал хураах тохиолдолд төлөөлөгч саналаа чөлөөтэй өгөх нөхцөл, боломжийг бүрэн хангах ажлыг хэрэгжүүлэх;
- 11.2.7 Санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх.
- 11.3 Тооллогын явцтай холбоотой маргаан гарсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл Их хурлаас тооллогын комиссыг шинээр сонгож хяналтын тооллого хийлгүүлнэ.

Хоёрдугаар дэд бүлэг. Холбооны Удирдах зөвлөл

12 дугаар зүйл. Удирдах зөвлөл

- 12.1 Удирдах зөвлөл нь Их хурлын чөлөө цагт Холбоог удирдлагаар хангах, бодлогыг тодорхойлох чиг үүрэгтэй, хамтын удирдлага мөн.
- 12.2 Удирдах зөвлөлийн гишүүдийн тоо арван ес байна
- 12.3 Удирдах зөвлөл нь Их хурлаас гаргасан шийдвэр, зөвлөмжийг биелүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ба үйл ажиллагаагаа Их хуралд тайлагнана.
- 12.4 Удирдах зөвлөлийн үйл ажиллагаагаа явуулах хэлбэр нь хурал байна.
- 12.5 Гүйцэтгэх захирлын удирдлагад ажиллах ажилтан Удирдах зөвлөлд давхар ажиллахгүй.
- 12.6 Удирдах зөвлөл нь түүний удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Ажлын албатай байна. Ажлын алба төсөвтэй байна.



13 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн хороод

13.1 Удирдах зөвлөлийн гишүүд нь дараах 4 үндсэн чиг үүрэг бүхий менежментийн хороодод сонгогдон ажиллана. Үүнд:

13.1.1 Стратеги, бодлогын менежментийн хороо: Мэргэжлийн байгууллагын бодлого, стратеги, хууль эрх зүй, засаглал, нөлөөлөл, бизнесийн загварчлал, санхүү хөрөнгө оруулалт, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, менежменттэй холбоотой бусад бодлого тодорхойлж чиглүүлнэ.

13.1.2 Ёс зүйн менежментийн хороо: Ёс зүй, чанарын хяналт, зорилгод нийцсэн туршлагыг гишүүдэд олгох ба тэдний мэргэжлийн дуу хоолой болж, хөгжүүлэхэд манлайлах зэрэг мэргэжлийн хариуцлагатай холбогдох бусад бодлого тодорхойлж чиглүүлнэ.

13.1.3 Сургалт, судалгааны менежментийн хороо: Олгож буй мэргэжлийн зэрэгтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах, шинэчлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжил, стандарт, арга зүй боловсруулах, хангах, ирээдүйн хэрэгцээг хангах, нийгэмд хувь нэмэр оруулах ур чадвар бүхий төрөл бүрийн мэргэжлийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа болон мэргэжлийн үйлчилгээ, бүтээгдэхүүний төрөлжилт, хөгжүүлэлттэй холбогдох бодлого тодорхойлж чиглүүлнэ.

13.1.4 Гишүүнчлэл, хамтын ажиллагааны менежментийн хороо: Гишүүдийн оролцоо, үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрх ашгийг хамгаалах, тэдний хүртэх үр өгөөжийг тодорхойлж нэмэгдүүлэх, гишүүдийн ангиллыг өргөжүүлэх, сурталчлах, бодлогод нөлөөлөх үйл ажиллагаа сайжруулах, олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлого тодорхойлж чиглүүлнэ.

13.2 Удирдах зөвлөл нь бодлогын хороодоос гадна Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх гэсэн засаглалын хороодтой байж болно.

14 дугаар зүйл. Удирдах зөвлөл бүрэн эрхийн хугацаа

14.1 Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх ба дараагийн Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон батламжлах хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

14.2 Их хурлаас Удирдах зөвлөлийн гишүүнээр батламжилснаар Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх үүсэх ба өмнөх гишүүний бүрэн эрх дуусгавар болно.



15 дүгээр зүйл. Удирдах зөвлөлийн бүрэн эрх

15.1 Удирдах зөвлөл дараах бүрэн эрхтэй байна.

15.1.1 Холбооны богино, дунд хугацааны стратеги тодорхойлох, бодлогын баримт бичиг боловсруулах, төсөл хөтөлбөр батлах;

15.1.2 Удирдах зөвлөлийн ажиллах журам батлах;

15.1.3 Удирдах зөвлөлийн хороодын үйл ажиллагаандаа мөрдөх журмыг батлах;

15.1.4 Холбооны үйл ажиллагааны бүтэц нэгжүүдийн зохион байгуулалт, түүний ажиллах журмыг батлах;

15.1.5 Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч сонгох, чөлөөлөх;

15.1.6 Менежментийн хорооны гишүүдийг сонгох, томилох, чөлөөлөх;

15.1.7 Удирдах зөвлөлийн Ажлын албаны бүтэц, чиг үүргийг тодорхойлох;

15.1.8 Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоон сонгон шалгаруулж, Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах эрхийг Ерөнхийлөгчид олгох;

15.1.9 Холбооны Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;

15.1.10 Холбооны Гүйцэтгэх захирлын ажлын албаны зохион байгуулалт, орон тоог батлах;

15.1.11 Хараат бус аудитын байгууллагыг сонгох, гэрээ байгуулах, аудитын байгууллагын шалгалтын үр дүнг хэлэлцэж, зохих шийдвэр гаргах;

15.1.12 Холбооны дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, тайланг хэлэлцэн батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

15.1.13 Холбооны хөрөнгийг захиран зарцуулах эрх олгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх;

15.1.14 Холбооны бэлгэ тэмдэг, далбааны санаа, загварт өөрчлөлт оруулах;

15.1.15 Мэргэжлийн, салбарын зэрэг бий болгох, зэргийн шалгуурыг тогтоох, зэрэг олгохтой холбоотой харилцааг зохицуулах журмыг батлах,

15.1.16 Холбогдох төрийн байгууллагаас тухайлан эрх олгосон тохиолдолд Мэргэшлийн зэрэг олголт, сунгалтыг батламжлах;



- 15.1.17 Холбооны гишүүнчлэл, гишүүний бүртгэл, гишүүний татвар, тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулах журмуудыг батлах;
- 15.1.18 Аюулгүй байдал, хамгаалалтын салбар, ажил мэргэжлийн чиглэлээр хороо байгуулах;
- 15.1.19 Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах Ёс зүйн дүрмийг батлах;
- 15.1.20 Гишүүдийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, ёс зүйн талаар гаргасан гомдол, маргааныг шалган шийдвэрлэх журмыг батлах;
- 15.1.21 Мэргэжлийн хариуцлага, ёс зүйн менежментийн хорооны санал дүгнэлтийг хэлэлцэх, зөрчил гаргасан этгээдэд сануулах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх;
- 15.1.22 Төрөөс тухайлан эрх олгосон бол Гэрээт харуул хамгаалалт, Хувийн хамгаалалт, бие хамгаалагчийн болон адилтгах бусад үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгох, цуцлах;
- 15.1.23 Холбооны "Хүндэт гишүүн" -ийг тодруулж, өргөмжлөх;
- 15.1.24 Холбооны шагнал бий болгох, шагналын журмыг батлах;
- 15.1.25 Их хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлах;
- 15.1.26 Удирдах зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гаргах, санал оруулах, хурлын зар хүргэхтэй холбоотой, дүрмийн энэ бүлэгт зохицуулаагүй харилцааг журамлах;
- 15.1.27 Бүрэн эрхэд хамаарах бусад асуудал.

16 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн хурал, хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

16.1 Удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонх хуралд оролцоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирц бүрдээгүй шалтгаанаар хойшлогдсон хурлыг ажлын 5 өдрийн дотор зарлан хуралдуулах ба хурлаар хэлэлцэх асуудалд өөрчлөлт орохгүй.

16.2 Удирдах зөвлөлийн анхдугаар хуралдааныг хамгийн ахмад настай удирдах зөвлөлийн гишүүн даргална. Удирдах зөвлөлийн анхны хуралдаанаар Удирдах зөвлөлийн дарга бөгөөд Ерөнхийлөгчийг сонгоно. Цаашид удирдах зөвлөлийн хурлыг Удирдах зөвлөлийн дарга бөгөөд Ерөнхийлөгч удирдана.



16.3 Хурлаар хэлэлцэх асуудлыг гишүүдийн ердийн олонхын саналаар шийдвэрлэх бөгөөд хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд гишүүн бүр нэг саналын эрх эдэлнэ.

16.4 Удирдах зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар хэлэлцэх асуудалд саналаа ирүүлсэн бол хуралд оролцсонд тооцно.

16.5 Хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар нууцаар санал хураах тухай гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувь нь санал гаргасан бол нууцаар явуулна. Бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна.

16.6 Холбооны ээлжит бус Их хурлыг хуралдуулах тухай асуудлыг Удирдах зөвлөлийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

16.7 Удирдах зөвлөлөөс гарах шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд өөрөөр заагаагүй бол тогтоол гармагц хүчин төгөлдөр болно.

16.8 Удирдах зөвлөл нь хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдана.

17 дүгээр зүйл. Удирдах зөвлөлийн гишүүний үүрэг, хариуцлага

17.1 Удирдах зөвлөлийн гишүүн дараах үүрэг хүлээнэ.

17.1.1 Удирдах зөвлөлийн хуралд идэвх, санаачилгатай оролцох;

17.1.2 Хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж, бэлтгэсэн байх;

17.1.3 Удирдах зөвлөлийн чиг үүргийн болон бусад хороодод бүтээмжтэй ажиллах;

17.1.4 Холбооны бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

17.1.5 Холбооны бодлого, зорилтын хэрэгжилтэд хяналт тавих;

17.1.6 Холбооны гишүүдийн уулзалтад ажлаа тайлагнадаг байх.

17.1.7 Удирдах зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаангүйгээр 3 удаа дараалан Удирдах зөвлөлийн хурал тасалсан бол Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөнө.

18 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох

18.1 Дараах тохиолдолд Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно.

18.1.1 Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөөр өөрөө хүсэлт гаргасан



18.1.2 Гишүүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон;

18.1.3 Гишүүн нэг жил, түүнээс дээш хугацаагаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;

18.1.4 Ёс зүйн хариуцлага хүлээж Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдсөн.

19 дугаар зүйл. Удирдах болон эрх бүхий албан тушаалтан, баримтлах зарчим, хариуцлага

19.1 Холбооны Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал нь удирдах албан тушаалтанд тооцогдоно.

19.2 Холбооны Удирдах зөвлөлийн гишүүд, хорооны дарга, гишүүд, Удирдах зөвлөлийн ажлын албаны дарга нь эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.

19.3 Удирдах болон эрх бүхий албан тушаалтнууд үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

19.3.1 Холбоо, түүний гишүүдийн эрх, ашгийг дээдлэх;

19.3.2 Өөрийн эрх мэдлийн хүрээнд ажиллах;

19.3.3 Шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх, сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

19.3.4 Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд бусдаас бэлэг, урамшуулал авахгүй байх;

19.3.5 Холбооны болон гишүүний нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх.

19.4 Удирдах болон эрх бүхий албан тушаалтнууд өөрийн хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас Холбоонд учруулсан хохирлыг хариуцан барагдуулна.

Гуравдугаар дэд бүлэг. Холбооны Ерөнхийлөгч

20 дүгээр зүйл. Ерөнхийлөгч

20.1 Холбооны Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дарга байна. Ерөнхийлөгч нь нэг удаа улиран сонгогдож болно.

20.2 Ерөнхийлөгч дэргэдээ тодорхой чиг үүрэг бүхий түр хороо байгуулж болно. Түр хорооны чиг үүрэг Холбооны бүтэц, нэгжийн чиг үүрэгтэй давхцалгүй байна.

20.3 Холбооны бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангуулахад анхаарч, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад бодлогын болон хүний нөөцийн асуудлаар



зөвлөх чиг үүрэг бүхий өмнөх Ерөнхийлөгчдөөс бүрдсэн Ерөнхийлөгчдийн зөвлөлтэй байж болно.

21 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрх

21.1 Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

21.1.1 Холбооны гадаад, дотоодод төлөөлөх;

21.1.2 Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах, хурлыг даргалах;

21.1.3 Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх саналыг Удирдах зөвлөлд оруулах;

21.1.4 Удирдах зөвлөлийн олгосон эрхийн хүрээнд Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах;

21.1.5 Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлаар гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд саналын эрх эдлэх;

21.1.6 Удирдах зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээний бусад асуудал.

21.2 Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд гаргах шийдвэр нь даалгавар, зөвлөмж хэлбэртэй байна.

21.3 Шаардлагатай тохиолдолд Ерөнхийлөгчийн үүргийг Удирдах зөвлөлийн гишүүн орлож болох бөгөөд энэ шийдвэрийг Ерөнхийлөгчийн хүсэлтээр Удирдах зөвлөл гаргана.

21.4 Ерөнхийлөгч дэргэдээ хорооны үйл ажиллагааг удирдуулах, зохион байгуулах зорилгоор Удирдах зөвлөлөөс сонгосон Дэд ерөнхийлөгчтэй байж болно.

Дөрөвдүгээр дэд бүлэг. Холбооны Гүйцэтгэх захирал

22 дугаар зүйл. Гүйцэтгэх захирал

22.1 Гүйцэтгэх захирал нь Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах бүтцийг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

22.2 Гүйцэтгэх захирал Ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажиллах бөгөөд Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийн хугацаа, эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал, албан тушаалаас чөлөөлөх үндэслэл зэрэг асуудлыг гэрээгээр зохицуулна.

22.3 Гүйцэтгэх захирал чиг үүргээ багийн зарчмаар гүйцэтгэнэ.



23 дугаар зүйл. Гүйцэтгэх захирлын бүрэн эрх

23.1 Гүйцэтгэх захирал дараах бүрэн эрхтэй байна.

23.1.1 Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах, Удирдах зөвлөлөөс олгосон эрхийн хүрээнд Холбоог гадаад, дотоодод төлөөлөх;

23.1.2 Холбооны үйл ажиллагааг уялдуулах, нэгдмэл байдлыг хангах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

23.1.3 Ажлын албаны нэгжийн бүтэц, бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын санал болгосноор Удирдах зөвлөл батална;

23.1.4 Удирдах зөвлөлөөр батлагдсан төсвийн хүрээнд Холбооны төсөв, хөрөнгийг захиран зарцуулах;

23.1.5 Холбооны үйл ажиллагааны бүтцийн хүний нөөцийг томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэр гаргах, журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

23.1.6 Гишүүдийн үргэлжилсэн сургалтын багц цагийг тооцох аргачлал, журмыг батлах;

23.1.7 Гишүүдийн эрх ашигтай холбогдсон асуудлаар төрийн эрх барих дээд байгууллага хүртэл холбогдох газруудад санал оруулж, шийдвэрлүүлэх, энэ талаар олон нийтийн дэмжлэг авах ажлыг зохион байгуулах;

23.1.8 Гүйцэтгэх захиралд гэрээгээр олгосон бусад эрх.

23.2 Гүйцэтгэх захирал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл, Их хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгчөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.

23.3 Гүйцэтгэх захирлын гаргах шийдвэр нь тушаал хэлбэртэй байна.

23.4 Гүйцэтгэх захирал нь Холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

23.5 Холбоо нь гишүүд, нийтэд чиглэсэн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг бүхий байнгын болон түр хороо, алба, зөвлөл, төсөл, хөтөлбөр зэрэг зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагаагаар дамжуулан явуулна.



ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХОЛБООНЫ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

24 дүгээр зүйл. Хяналтын үйл ажиллагаа, баримтлах зарчим

- 24.1 Хяналтын зөвлөлийг их хурлаас сонгох ба гишүүдийн тоо 5 байна.
- 24.2 Холбоо нь хяналтын үйл ажиллагааг Хяналтын зөвлөлөөр хэрэгжүүлнэ. Хяналтын зөвлөл дэргэдээ Аудитын хороотой байж болно.
- 24.3 Хяналтын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлан ажиллана.
 - 24.3.1 Тогтмол хяналтыг зохистой хэрэгжүүлэх;
 - 24.3.2 Үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх, аливаа нөлөөлөлд автахгүй байх;
 - 24.3.3 Үйл ажиллагаандаа үнэн зөв, шударга, бодитой хандах.

25 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн Аудитын хороо

- 25.1 Аудитын хороонд холбооны засаглалын тогтолцоонд үнэлгээ хийх, сайжруулах чиг үүрэг байна.
- 25.2 Аудитын хороо нь дараах чиг үүрэгтэй байна.
 - 25.2.1 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын тогтолцоонд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөх;
 - 25.2.2 Удирдах зөвлөлийн бусад хороодын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөх;
 - 25.2.3 Дүрэм журмын хэрэгжилтэд үнэлгээ өгөх, өөрчлөлтийн санал гаргах;
 - 25.2.4 Хараат бус аудитыг сонгох, аудитын дүгнэлтийг хэлэлцэх.
- 25.3 Аудитын хороо нь үндсэн чиг үүргээ гадаад, дотоод судалгаа, олон улсын чиг хандлага, туршлага судлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.

26 дүгээр зүйл. Хяналтын зөвлөлийн чиг үүрэг

- 26.1 Хяналтын зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
 - 26.1.1 Холбооны Их хурал, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэрүүдийн хууль тогтоомжид нийцсэн эсэх, хоорондын уялдаа холбоо болон хэрэгжилтэд хяналт тавих;
 - 26.1.2 Холбооны нягтлан бодох бүртгэл холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд болон эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалтын үнэн бодит байдалд хяналт тавих;



26.1.3 Холбооны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох баримт бичгүүдийн бүрдэл, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалт, хөдөлгөөнд хяналт тавих;

26.1.4 Холбооноос бусад этгээдтэй байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй байж болзошгүй хэлцлийг зохих журмын дагуу байгуулсан эсэхийг шалгах;

26.1.5 Хяналт шалгалт хийсэн Холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээлэлд тулгуурлан Холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, Удирдах зөвлөл дэх төлөөллийн зохистой байдал, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох саналыг Удирдах зөвлөлд оруулах;

26.2 Хяналтын зөвлөлийн эрх, үүрэг

26.2.1 Хяналтын зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ, хяналт шалгалт хийх удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, шаардлагатай бусад баримт материалуудыг холбогдох этгээдээс саадгүй гаргуулан авах эрхтэй;

26.2.2 Хяналт, шалгалтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай байгаа мэдээ, мэдээллийн талаар Холбооны удирдах болон эрх бүхий албан тушаалтан, гишүүд болон ажилтнаас тайлбар авах эрхтэй.

26.2.3 Холбооны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд жил бүр хяналт шалгалт хийх үүрэгтэй;

26.2.4 Хийсэн шалгалтын ажлын үр дүн, тайланг тухай бүр Удирдах зөвлөлд танилцуулах үүрэгтэй.

26.3 Хяналтын зөвлөлийн энэ дүрмээр зохицуулаагүй харилцаа, үйл ажиллагааг Удирдах зөвлөлийн баталсан журмаар зохицуулж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ХОЛБООНЫ САНХҮҮ

27 дугаар зүйл. Холбооны санхүү

27.1 Холбоо нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар үйл ажиллагаагаа явуулах ба санхүүгийн дараах эх үүсвэртэй байна.

27.1.1 Гишүүдийн татвар ба хандив;

27.1.2 Дэмжигч, ивээн тэтгэгчдийн тусламж, дэмжлэг, хандив;

27.1.3 Хуульд заасан чиг үүрэг гүйцэтгэхтэй холбоотой санхүүжилт;



- 27.1.4 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн үйл ажиллагаа болон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;
- 27.1.5 Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрөөс олсон санхүүжилт;
- 27.1.6 Хууль тогтоомжийн дагуу олсон бусад эх үүсвэр.
- 27.2 Холбооны хөрөнгө нь эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад хөрөнгөөс бүрдэнэ.
- 27.3 Холбооны хөрөнгийг энэ дүрмээр заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт, урсгал зардлыг санхүүжүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн бусад зориулалтаар зарцуулна.
- 27.4 Жил бүрийн 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон салбаруудын санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт дараа оны 1 дүгээр улиралд багтаан Удирдах зөвлөлд тайлагнана.
- 27.5 Холбоо нь Аудитын дүгнэлт бүхий санхүүгийн тайланг гишүүд, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД

28 дугаар зүйл. Холбооны бүртгэл

- 28.1 Холбооны бүртгэл нь хувь хүний болон байгууллагын гишүүнчлэлийн бүртгэлээс бүрдэнэ.
- 28.2 Холбооны гишүүнд тавигдах шаардлага, гишүүний бүртгэлд орох мэдээлэл, бүртгэх хугацаа, гишүүний шилжилт хөдөлгөөн, бүртгэлээс хасах болон бүртгэлтэй холбогдон үүсэх аливаа харилцааг Удирдах зөвлөлийн баталсан журмаар зохицуулна.

29 дугаар зүйл. Холбооны өргөмжлөл, шагнал

- 29.1 Холбооны шагнал урамшууллын журмыг Удирдах зөвлөл батална.
- 29.2 Холбооны түүхэнд үнэтэй хувь нэмэр оруулсан, Аюулгүй байдал, хамгаалалтын салбарын хөгжилд онцгой гавьяа байгуулсан хувь хүн, байгууллагыг Холбооны "Хүндэт гишүүн" -ээр өргөмжилж болно.
- 29.3 Холбооны "Хүндэт гишүүн" нь холбооны хүндэтгэлийн арга хэмжээ, Их хуралд урилгаар оролцох эрхтэй.



30 дугаар зүйл. Хариуцлага

30.1 Холбоо нь гишүүнийхээ бусдын өмнө хүлээх үүргийг, мөн гишүүд нь холбооны хүлээх үүргийг тус тус хариуцахгүй.

30.2 Холбооны гишүүн, Удирдах зөвлөлийн гишүүн, ажилтны хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирол, түүнээс үүсэх хариуцлагыг Холбоо хүлээхгүй.

31 дүгээр зүйл. Холбоо төрийн болон бусад байгууллагатай харилцах

31.1 Холбоо нь төрөөс хараат бусаар үйл ажиллагаагаа явуулна. Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн байгууллагаас Холбооны үйл ажиллагаанд, Холбооноос төрийн байгууллагын үйл ажиллагаанд оролцохгүй.

31.2 Холбоо нь хуулийн хүрээнд Олон улсын болон бусад холбоо, эвсэлд нэгдэн орох, дэмжих, татгалзах, хамтран ажиллах нь нээлттэй байна.

32 дүгээр зүйл. Холбооны бүтцийн байгууллагын сонгууль явуулах нийтлэг зарчим

32.1 Холбооны бүтцийн байгууллагад сонгууль явуулахад энэ зүйлд заасан нийтлэг зарчмыг баримтална.

32.2 Сонгуулийг шударга, маргаангүй байх үүднээс дараах шаардлагыг хангасан байна.

32.2.1 Нийт гишүүдэд сонгуулийн товыг хангалттай хугацааны өмнө, зохих хэлбэрээр мэдэгдсэн байх;

32.2.2 Сонгууль явуулах журмыг тодорхой зарлан мэдэгдсэн байх;

32.2.3 Нэр дэвших, нэр дэвшүүлэх хугацаа, бусад боломжоор хангагдсан байх;

32.2.4 Нийт гишүүдийн олонх оролцсоноор сонгуулийн ирцийг хүчинтэйд тооцох.

33 дүгээр зүйл. Гишүүдийн сайн дурын үйл ажиллагаа

33.1 Гишүүд нь мэргэжлийн салбарын хүрээнд ур чадвараа нэмэгдүүлэх зорилгоор сайн дураар нэгдэж болно.

34 дугаар зүйл. Холбоо татан буулгах

34.1 Холбоо доор дурдсан тохиолдолд татан буулгана.



34.1.1 Хууль буюу дүрэмд заасан үндэслэлээр сайн дураараа Холбоог татан буулгахаар Их хурлаас шийдвэрлэсэн;

34.1.2 Дампуурсанд тооцогдсон;

34.1.3 Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

34.2 Холбоо татан буулгах, өөрчлөн зохион байгуулах үйл ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулна.

35 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох

35.1 Энэхүү дүрэм нь Их хурлаар батлагдсанаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

--oOo--

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

- | | | | |
|---------|----------------|---------|---------------|
| 1..... | Г.Эрдэнэцацрал | 11..... | Ц.Бүрэнбаатар |
| 2..... | С.Энхсайхан | 12..... | С.Отгонбаатар |
| 3..... | Р.Гантулга | 13..... | Д.Мөнхтүвшин |
| 4..... | Э.Бат-Эрдэнэ | 14..... | С.Шатар |
| 5..... | Л.Бат-Өлзий | 15..... | С.Гантулга |
| 6..... | Д.Чинзориг | 16..... | Т.Батзориг |
| 7..... | А.Ганхуяг | 17..... | Т.Аманкелд |
| 8..... | Л.Цэрэн | 18..... | Д.Мөнхтөр |
| 9..... | М.Сүхээ | 19..... | М.Мөнхбаатар |
| 10..... | Ж.Ерөөлтхуяг | | |

